



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 4, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”-ыг 1 дүгээр, “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлд шинэчилсэн дансны үнэ тогтоох ажилд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Х.Пүрэвсүрэн/-т даалгасугай.

САЙД



Ч.УЛААН

0 0374

Сангийн сайдын 2013 оны 06 сарын 17 өдрийн 240 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ, ҮЗМЭР, ЭД ӨЛГИЙН ЗҮЙЛИЙН ШИНЭЧИЛСЭН ДАНСНЫ ҮНЭ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагад хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн дансны үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгахад оршино.

1.2. Өмчийн бусад хэлбэрийн байгууллагад хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийн дансны үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгахад энэхүү журмыг ашиглаж болно.

1.3. Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийг санхүүгийн тайланд тусгахдаа УСНББОУС-17 (Улсын секторын нягтлан бүртгэлийн олон улсын стандарт) "Үндсэн хөрөнгө" болон бусад холбогдох журам, зааврыг баримтлана.

1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн түүх, соёлын дурсгалт зүйлийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн жагсаалт, үнэлгээнд хамруулах эсэх дүгнэлтийг Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гаргана.

1.5. Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлд хамаарахгүй хөрөнгийн бүртгэлийг залруулах, данснаас хасах, шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн хороо шийдвэрлэнэ.

Хоёр. Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлд шинэчилсэн дансны үнэ тогтоон, бүртгэлд тусгах

2.1. Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн дансны үнэ шинэчлэн тогтоох комиссыг (цаашид "комисс" гэнэ) тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилно. Комиссын бүрэлдэхүүнд байгууллагын нягтлан бодогч, сан хөмрөгч, өмч хамгаалах байнгын зөвлөл, техникийн комиссын төлөөллийг оролцуулбал зохино.

2.2. Комисс нь энэхүү журам, түүний хавсралт болох "Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн дансны шинэчилсэн дансны үнийн жагсаалт"-ыг баримтлан үнэ тогтоох бөгөөд үнэлгээний ажлын өдөр тутмын тэмдэглэлийг хөтөлнө.

2.3. Шинэчилсэн дансны үнийг тогтоохдоо тухайн зүйлийн түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, ховор, түгээмэл байдал, материал, бүтээсэн он цаг, ур хийц, арга ажиллагаа, жин, хэмжээ, иж бүрдэл, гэмтэл түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол зэргийг харгалзан шинэчилсэн дансны үнийг тодорхой хувиар өсгөж, бууруулж болно.

2.4. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийг түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэлд хамруулсан байдлыг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.4.1. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлээр батлагдсан үзмэрийн үнийг 50 хүртэлх хувиар;

2.4.2. Музейн брэнд үзмэрийн үнийг 30 хүртэлх хувиар;

2.4.3. "Үнэт" дурсгалт зүйлийн зэрэглэлд санал болгосон үзмэрийн үнийг 25 хүртэлх хувиар тус тус өсгөнө.

2.5. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн ховор байдлыг харгалзан шинэчилсэн дансны үнийг :

2.5.1. Нэн ховор үзмэрийн үнийг 40 хүртэлх хувиар,

2.5.2. Ховор үзмэрийн үнийг 20 хүртэлх хувиар тус тус өсгөж болно.

2.6. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдлыг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.6.1. Ач холбогдол ихтэй үзмэрийг 40 хүртэлх хувиар өсгөж,

2.6.2. Ач холбогдол багатай үзмэрийг 60 хүртэлх хувиар бууруулж болно.

2.7. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн хийсэн материалыг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.7.1. Үнэт металл, үнэт, хагас үнэт чулуугаар бүтээсэн бол 50 хүртэлх хувиар,

2.7.2. Үнэт металл, үнэт, хагас үнэт чулуу орсон бол 40 хүртэлх хувиар тус тус өсгөж болно.

2.8. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн бүтээсэн он цагийг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.8.1. Ижил төстэй үзмэр, эд өлгийн зүйлээсээ эрт үед бүтээгдсэн бол 30 хүртэлх хувиар өсгөж,

2.8.2. Ижил төстэй үзмэр, эд өлгийн зүйлээсээ хожуу цаг үед бүтээгдсэн бол 40 хүртэлх хувиар бууруулж болно.

2.9. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн ур хийц болон уран бүтээлчийг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.9.1. Маш нарийн ховор ур хийцтэй бол 30 хүртэлх хувиар өсгөж,

2.9.2. Нарийн ур хийцтэй бол 20 хүртэлх хувиар өсгөж,

2.9.3. Нэрт бол алдар цуутай уран бүтээлчийнх бол 20 хүртэлх хувиар өсгөж,

2.9.4. Ердийн хийцтэй бол 50 хүртэлх хувиар бууруулж болно.

2.10. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийг хийсэн арга ажиллагааг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.10.1. Хийсэн арга ажиллагаа нь нэн ховорд тооцогдох бол 30 хүртэлх хувиар өсгөж,

2.10.2. Хийсэн арга ажиллагаа нь ховорд тооцогдох бол 20 хүртэлх хувиар өсгөж,

2.10.3. Үйлдвэрийн болон хэвлэх, хуулбарлах аргаар хийсэн бол 70 хүртэлх хувиар бууруулж болно.

2.11. Хуулбар үзмэрийг шинэчилсэн дансны үнийн дүнгээс 60 хүртэлх хувиар бууруулж болохоос гадна хуулбар хийсэн өртөгийг баримталж болно.

2.12. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн жин, хэмжээг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.12.1. Ижил төстэй үзмэр, эд өлгийн зүйлээс жин, хэмжээ том бол 50 хүртэлх хувиар өсгөж,

2.12.2. Ижил төстэй үзмэр, эд өлгийн зүйлээс жин, хэмжээ бага бол 30 хүртэлх хувиар бууруулж болно.

2.13. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн иж бүрдлийн байдлыг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.13.1. Үзмэр, эд өлгийн зүйлийн бүрдлээс 10-20% нь дутуу бол 20 хүртэлх хувиар бууруулж,

2.13.2. Үзмэр, эд өлгийн зүйлийн бүрдлээс 20-40% нь дутуу бол 40 хүртэлх хувиар бууруулж,

2.13.3. Үзмэр, эд өлгийн зүйлийн бүрдлээс 40-70% нь дутуу бол 60 хүртэлх хувиар бууруулж,

2.13.4. Үзмэр, эд өлгийн зүйлийн бүрдлээс 70-90%-нь дутуу бол 80 хүртэлх хувиар бууруулж болно.

2.14. Тухайн үзмэр, эд өлгийн зүйлийн эвдрэл, гэмтлийн байдлыг харгалзан шинэчилсэн дансны үнийг:

2.14.1. Үзмэр, эд өлгийн зүйл нь 60%-80% гэмтэлтэй бол 20 хүртэлх хувиар бууруулж,

2.14.2. Үзмэр, эд өлгийн зүйл нь 40%-60% гэмтэлтэй бол 15 хүртэлх хувиар бууруулж,

2.14.3. Үзмэр, эд өлгийн зүйл нь 20%-40% гэмтэлтэй бол 10 хүртэлх хувиар бууруулж,

2.14.4. Үзмэр, эд өлгийн зүйл нь 5%-10% гэмтэлтэй бол 5 хүртэлх хувиар бууруулж болно.

2.15. Шинэчилсэн дансны үнийн өсгөх, бууруулах хувийг журмын 2 дугаар хавсралтаар баталсан "Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт"-аас тооцно.

2.16. Төсөвт байгууллагын үзмэр, эд өлгийн зүйлийн хуучин болон шинэчилсэн дансны үнийн зөрүүг стандартын дагуу Дахин үнэлгээний нэмэгдэл данснаас холбогдох үндсэн хөрөнгийн дансны дебет дансанд бүртгэнэ.

Дт. Үндсэн хөрөнгө
Кт. Дахин үнэлгээний нэмэгдэл

2.17. Санхүүгийн тайлан болон түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн тооллогын бүртгэлд тусгасан дансны үнийг Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тухайн жилийн инфляцийн түвшинтэй уялдуулан өсгөж, бууруулах саналыг боловсруулж болно.

2.19. Шинэчлэн тогтоосон дансны үнэ нь хуучин дансны үнээс доогуур гарч байгаа тохиолдолд хуучин дансны үнийг баримталж болно.

2.20. Улс, орон нутгийн музей болон төрийн байгууллагад бэлэг, хандиваар хөрөнгийг УСНБББОУС 17 “Үндсэн хөрөнгө” гэсэн стандартын 27дуаар зүйлийн дагуу “хөрөнгийг солилцооны бус ажил гүйлгээний явцад олж авсан үед түүний өртөг нь худалдан авсан өдрийн бодит үнэ цэнэ байна” гэсэн заалтын дагуу үнэлж бүртгэнэ.

2.21 Бэлэг, хандиваар хүлээн авсан хөрөнгийг УСНБББОУС 23 “Арилжааны бус ажил гүйлгээний орлого” гэсэн стандартын дагуу орлогоор хүлээн зөвшөөрч дараахь байдлаар бүртгэнэ.

Дт. Үндсэн хөрөнгө
Кт. Тусламжийн орлого

2.21. Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлд нэг хувийн дугаарт олон тоогоороо бүртгэгдсэн нэг эх сурвалжтай ижил буюу ижил төстэй (нэг хэвийн бурхад, цөгц, гэрэл зураг, биримт бичиг, зэв, чулуун зэвсэг, цуврал эскиз зураг г.м) үзмэр, эд өлгийн зүйлийн үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан бүртгэлийн үнийг нийтэд нь буюу нэг бүрчлэн тогтоон нэгтгэж болно. Нийтэд нь үнэлж байгаа тохиолдолд үлгэрчилсэн үнийн дүнг 50 хүртэлх хувиар өсгөж болох ба нэг бүрчлэн тогтоон нэгтгэн гаргах тохиолдолд нэг бүрийн үнэлгээг 80 хүртэлх хувиар бууруулж нийт үнийг тооцож болно.

2.22. Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлд нэг хувийн дугаарт бүртгэгдсэн өөр өөр эх сурвалж, материал, төрөл зүйлд хамаарах үзмэр, эд өлгийн зүйлийг тус бүрд нь үнэлж нэгтгэнэ.

2.23. Шинэчилсэн дансны үнийн жагсаалтад ороогүй түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийг ижил төстэй төрөл, зүйлд нь хамааруулан дансны үнийг тогтооно.

2.24. Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйл нь энэхүү журмын хавсралтад заасан шинэчилсэн дансны үнийн жагсаалтын хэд хэдэн төрөлд хамаарч байвал тухайн музейн үндсэн чиглэл, үзмэрийн бодит байдлыг харгалзан зөв төрөлд нь хамруулан үнэлнэ.

--- о О о ---